

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

БАТЛАВ



Л.ЦЭНГҮҮНЖАВ

“ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ” ТӨХХК-ИЙН  
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024.01.31

Улаанбаатар хот

№	Зорилго	№	Хэрэгжүүлэх ажил	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжүүлэх хугацаа
1.	Авлигын эсрэг, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх, авлигыг үл тэвчих ёс зүйг төлөвшүүлэх	1.1	Авлигын хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр соён гэгээрүүлэх үйл ажиллагааг дэмжин ажиллах, Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг компанийн цахим хуудас, фэйсбүүк зэрэг нийгмийн цахим сүлжээгээр, боломжит хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэх, Авлигатай тэмцэх газраас санаачилсан, зохион байгуулсан аян, арга хэмжээг байгууллагын онцлогт тохируулан зохион байгуулах, дэмжин ажиллах	Баримтжуулан, үр дүнг тооцож тайлагнасан байх; Цахим сүлжээгээр олон нийтэд түгээсэн арга хэмжээ, тоо	I-IV улиралд
		1.2	Авлигын эсрэг, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг компанийн төв оффист болон “Чингис хаан” олон улсын нисэх буудалд ажиллуулах, Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн сурталчилгааны материал, мэдээллийг байршуулсан байх	Мэдээллийг тогтмол шинэчилсэн байх; Баримтжуулан тайланд хавсаргасан байх.	I-IV улиралд
		1.3	Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга, уриа, аянд нэгдэх;	Нэгдсэн, хамрагдсан санал, санаачилга, уриа, аяны нэр, тоо.	I-IV улиралд
		1.4	Авлигатай тэмцэх газар, Зам, тээврийн хөгжлийн яамнаас зохион байгуулах авлигын эсрэг, авлигаас урьдчилсан сэргийлэх сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан албан тушаалтан, ажилтны тоо	I-IV улиралд

2.	Хууль тогтоомжийн биелэлтийг хангах	2.1	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө өгөх асуудлыг хэрэгжүүлэх	ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд бүрэн мэдүүлж баталгаажуулсан байх; Тайланг холбогдох журамд заасан хугацаанд Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн байх.	I улиралд
		2.2	Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичгийн дагуу холбогдох арга хэмжээг шуурхай авч, хэрэгжүүлсэн арга хэмжээг мэдээлэх, тайлагнах	Арга хэмжээг авч хэрэгжүүлэн тайлан мэдээг хүргүүлсэн байх.	I-IV улиралд
		2.3	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /2023-2030/, тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсээс хүргүүлсэн зөвлөмжийн дагуу арга хэмжээг авч хэрэгжүүлэх, тайлагнах	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар холбогдох тайланг хүргүүлсэн байх.	I-IV улиралд
3.	Компанийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах	3.1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-д заасныг мөрдөж ажиллах	Хуулийн хэрэгжилтийг бүрэн хангасан байна; Үр дүнг тооцож тайлагнасан байх; Нийт мэдээлсэн мэдээллийн төрөл, тоо	I-IV улиралд
		3.2	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг байгууллагын албан ёсны цахим хуудсанд тогтмол байршуулах	Хуулийн хэрэгжилтийг бүрэн хангасан байна; Үр дүнг тооцож тайлагнасан байх; Мэдээлсэн нээлттэй мэдээллийн төрөл, тоо	I-IV улиралд
		3.3	Байгууллагын цахим хуудасны мэдээллийг шинэчлэх	Цахим хуудсанд шинэчилсэн мэдээллийн төрөл, тоо	I-IV улиралд
		3.4	Өргөдөл, гомдлыг цахим хуудсаар хүлээн авах нөхцөлийг бүрдүүлж, ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухай бүр шийдвэрлэж хариу өгөх	Ирсэн, шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо	I-IV улиралд
		3.5	Сул орон тоонд ажилтан сонгон шалгаруулах журмыг нээлттэй болгож, үйл ажиллагаандаа мөрдөх	Сул орон тооны нээлттэй сонгон шалгаруулалтын тоо, мэдээлэл	I-IV улиралд

4.	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	4.1	Удирдлагын зүгээс компанийн авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг 2024 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилээр, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцэст тооцож биелэлтийг тайлагнана.	Төлөвлөгөөг боловсруулж Авлигатай тэмцэх газрын холбогдох эрх бүхий албан тушаалтанд танилцуулсан байна; Биелэлтийн тайланг хагас жил, жилээр тайлагнасан байна.	I-IV улиралд
		4.2	Авлигатай тэмцэх газар, салбарын яамнаас ирүүлсэн санал, зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлэх, төлөвлөгөө, холбогдох дүрэм журамд тусгах	Тусгасан санал, зөвлөмж, чиглэлийн тоо, хэрэгжүүлсэн байдал	I-IV улиралд
		4.3	Авлигын эрсдэл үүсэх шалтгаан нөхцөлийг бий болгохгүй байх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээ, зөвлөмж бэлтгэх, шийдвэр гаргах процесс, байгууллагын дотоод хяналт, зохион байгуулалтыг сайжруулах	Байгууллагын дотоод үйл ажиллагаа, шийдвэр гаргах процесст удирдах албан тушаалтнуудын хамтын удирдлага, хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.	I-IV улиралд
		4.4	Аливаа гэрээ хэлцэл байгуулах, худалдан авах ажиллагаа (ХАА)-г хэрэгжүүлэхэд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах	ХАА-ны журмыг баримтлан ажиллаж, гэрээ байгуулахдаа ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэх, авлигаас ангид байх, авлигыг мэдээлэх үүрэг болон гэрээний талуудын үүрэг хариуцлага, хохирол барагдуулах асуудлыг тусгасан байна; Тайланд нотломжийг хавсаргасан байх.	I-IV улиралд

---ooOoo---